

**ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ЭРҮҮГИЙН
ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Хуулийн төсөл санаачлан
боловсруулагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Гүйцэтгэгчийн нэр:

Г.Сувд-Эрдэнэ

2025 он

Агуулга

Агуулга	2
Товчилсон үгийн тайлбар.....	3
Оршил	3
Үнэлгээний хамрах хүрээ	4
Төрийн байгууллагад үүсэх зардал, ачаалал.....	5
А.ГБХШХШтХТ-ийн зохицуулалтуудад хийх зардлын тооцоо.....	7

Зохицуулалт 1.Гэр бүлийн хэрэгт сэтгэлзүйч оролцсон баг оролцохтой холбоотой үүсэх хүний нөөцийн зардал.....

Зохицуулалт 2.Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчтэй холбоотой үүсэх хүний нөөцийн зардал.....

Б. ЭХХШтХНӨтХТ-ийн зохицуулалтад хийх зардлын тооцоо.....	17
---	----

Зохицуулалт 3.Хүүхдийн үйлдсэн эрүү, зөрчлийн хэргийн мөрдөн шалгах үе шатанд сэтгэл зүйч оролцуулахтай холбогдуулан Цагдаагийн байгууллагад үүсэх зардал

Үнэлгээний үр дүн.....	19
Ашигласан эх сурвалжийн жагсаалт	21

Товчилсон үгийн тайлбар

ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ГБХШХШтХТ	Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл
ЭХХШтХНӨОтХТ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
Аргачлал	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл

Оршил

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.¹

Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд дээрх зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан.²

Түүнчлэн, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-т нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн болон давж заалдах шатны шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг даалгасан.

Ийнхүү ХЗДХЯ-ны боловсруулж байгаа ГБХШХШтХТ, ЭХХШтХНӨОтХТ-ийн холбогдох хэсэгт нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу зардлын тооцоог хийнэ.

Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог 2015 онд баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу гүйцэтгэдэг бөгөөд тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721217671>

Энэ нь аливаа хууль тогтоомжийн улмаас улс орны эдийн засаг болон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсч байгаа захиргааны зардал, ачааллыг тооцоолох, шаардлагагүй бол бууруулах зохицуулалтын хувилбарыг боловсруулахад чухал ач холбогдолтой.

Энэхүү зардлын тооцоог хийхэд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримтална.³

Энэхүү зардлын тооцооны тайланд хуулийн төслөөр шинээр зардал бий болгох зохицуулалтуудыг сонгож, зардлын тооцоо гаргалаа.

Түүнчлэн, зардлын тооцоог хийхэд нийтэд ил болгосон мэдээлэл болон холбогдох байгууллагаас авсан албан ёсны тоон мэдээллийг ашигласан хэдий ч зардлын тооцоонд ашигласан мөнгөн дүн, үнэ нь зөвхөн гарах зардалд баримжаа өгөх зорилготой тул хууль батлагдсаны дараа хуулийг хэрэгжүүлэхэд бодитоор гарах зардлаас ялгаатай байх боломжтой гэдгийг анхаарна уу.

Үнэлгээний хамрах хүрээ

Хуулийн төслөөс сонгон зардал тооцох зохицуулалт буюу үнэлгээний хүрээний тухайд Аргачлалын дагуу иргэн, хуулийн этгээдэд шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй бол зардал, ачааллыг тооцдоггүй. Төрийн байгууллагын хувьд өмнө нь хэрэгжүүлж байсан чиг үүрэгт өөрчлөлт ороогүй бол мөн зардал тооцохгүй бөгөөд хуулийн төсөлд хамаарах үндсэн байгууллагад үүсэх ачаалал болон улсын төсөвт их хэмжээгээр үүсгэх зардлыг голчлон тооцох зарчмыг баримталдаг.

Хуулийн төсөлд өмнө нь байгаагүй цоо шинэ зохицуулалт үүсгэсэн буюу иргэн, хуулийн этгээдэд хамаарах үүрэг бий болгосон зохицуулалт тусгагдсан бол түүнээс үүсэх зардлыг тооцдог.

Гэр бүл, хүүхдийн хэрэгт хуулийн этгээдэд зардал үүсэхгүй болно.

Төрийн байгууллагад үүсэх зардлын тухайд Нийслэлд Гэр бүл, хүүхдийн анхан шатны тойргийн шүүх байгуулагдсантай холбогдуулан, түүнчлэн бусад нутаг дэвсгэрт иргэний хэргийн анхан шатны шүүх гэр бүлийн хэргийг шийдвэрлэхэд хүний нөөцийн зардал үүсгэхээр байна.


Түүнчлэн хүүхдийн үйлдсэн эрүү, зөрчлийн хэргийн мөрдөн шалгах үе шатанд хүүхдээс мэдүүлэг авахдаа сэтгэлзүйч оролцуулахаар тусгасан зохицуулалт нь хүний нөөцийн зардал үүсгэхээр байна.

³ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”

Иймд хуулийн төслөөс доорх зүйл, хэсэг, заалт дахь зохицуулалтыг сонгон авч зардал, ачааллыг тооцов. Үүнд:

Төрийн байгууллагад шинээр үүсэх зардал, ачаалал

Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг, үүнд шүүхэд үүсэх шүүгчийн зардлыг дараах үе шатаар тооцно. Үүнд:



Харин гэр бүлийн хэрэг, хүүхдийн үйлдсэн хэрэг маргааныг шийдвэрлэхэд сэтгэлзүйч оролцох, гэр бүлийн хэрэгт гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч оролцох тохиолдлын тоог тогтоох боломжгүй тул Аргачлалын 4.4.5.2-т зааснаар хүний нөөцийн хэрэгцээг баримжаалан тооцно.

А.ГБХШХШТХТ-ийн зохицуулалтад хийх зардлын тооцоо

Төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллын хувьд Нийслэлд Гэр бүл, хүүхдийн анхан шатны тойргийн шүүх болон бусад нутаг дэвсгэрт иргэний хэргийн анхан шатны шүүх гэр бүлийн холбогдолтой хэргийг шийдвэрлэхэд сэтгэлзүйч оролцуулах, гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчээр гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлуулахтай холбоотойгоор улсын төсөвт үүсэх зардал, ачааллыг тооцно.

Хүснэгт 1. Зардал тооцоох үе шат, алхам /шүүх/

Төрийн байгууллагад үүсэх зардал, ачаалал

- Үүргийг тогтоох
- Хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг тооцох
- Зардлыг нэгтгэн тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, танилцуулах

Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын зардлын хүрээнд тухайн ажил үйлчилгээг /шинээр бий болох үүргийг/ гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцно. Үүнд:

Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох зохицуулалт

Аргачлалаар тогтоосон үе шат, дарааллын дагуу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрт зарцуулах цаг хугацааг тооцох боломжтой, шүүхийн дараах үүргийн хүний нөөцийн зардлыг тооцон гаргана. Үүнд:

ГБХШХШтХТ-ийн

- | | | |
|----|---|---|
| 1. | | <i>Сэтгэлзүйч хүүхэдтэй холбоотойгоор гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тохиолдолд оролцоно.</i> |
| | 34.2.Шаардлагатай тохиолдолд эвлэрүүлэн зуучлалын шүүгч гэрлэгчдийг сэтгэлзүйчтэй уулзуулах арга хэмжээ авахыг эвлэрүүлэн зуучлалын хороонд даалгана. | |

ГБХШХШтХТ-ийн

- | | | |
|----|---|--|
| 2. | | <i>Гэр бүлийн нөхцөл байдлыг шаардлагатай тохиолдолд шүүгчийн захирамжийн дагуу шинжлэн судална.</i> |
| | 16.1.Шүүхэд гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах чиг үүрэг бүхий шүүхийн ажилтан байна. | |

Б.ЭХХШтХНӨтХТ-ийн зохицуулалтад хийх зардлын тооцоо

Төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллын хувьд хүүхдийн үйлдсэн эрүү, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд сэтгэлзүйч оролцохоор байгаатай холбоотойгоор цагдаагийн байгууллагад үүсэх хүний нөөцийн зардалтай холбоотойгоор улсын төсөвт үүсэх зардал, ачааллыг тооцно.

Хүснэгт 2.Цагдаагийн байгууллагад үүсэх хүний нөөцийн зардыг урьдчилан тооцох зохицуулалт

№	Зохицуулалт	Тооцох зардал
1	ЭХХШтХНӨтХТ-ийн 2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн,” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “холбогдох хэргийг” гэсний дараа “мөрдөн шалгах,” гэж, 14.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “үйлдсэн бол” гэсний дараа “энэ хуульд заасан өөр таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй тохиолдолд” гэж, 18.2 дугаар зүйлийн	Хүүхдээс мэдүүлэг авахад сэтгэлзүйч заавал оролцох

1,2,3,4 дэх хэсгийн “Өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн, яллагдагч,” гэж, 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “сурган хүмүүжүүлэгчийг” гэсний өмнө “сэтгэлзүйч” гэж тус тус нэмсүгэй.

Нэг.Төрийн байгууллагад үүсэх хүний нөөцийн зардал

Энэ хэсэгт хуулийн төслийн төрийн захиргааны байгууллага, шүүхэд үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад буюу төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцно.

Төрийн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хэрэгжих боломжийг тодорхойлоход ач холбогдолтой.

Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг дараах үе шатаар тооцно.
Үүнд:

- Үүргийг тогтоох
- Хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг тооцох
- Зардлыг нэгтгэн тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, танилцуулах

Үүнд, стандарт үйл ажиллагааг тогтоож, хүний нөөцийн зардал буюу зарцуулах цаг хугацааг тооцох боломжтой үүргийг дээрх дарааллын дагуу тооцож нэгтгэн гаргана.

1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, зарцуулах хугацаа

А.ГБХШХШтХТ-тэй холбогдуулан төрийн байгууллагад үүсэх зардал

Хуулийн төсөлд шүүхийн байгууллагад шинээр үүрэг оноосон зохицуулалтууд тусгагдсан байна.

Ийнхүү Аргачлалд заасны дагуу хуулийн төсөл дэх гүйцэтгэх үүрэг, ажил үйлчилгээнд хамааралтай шинэ чиг үүрэг нэмэгдэж байгаа шүүхийн байгууллагын хувьд холбогдох зохицуулалтыг сонгон зардал, ачааллыг тооцов. Ингэхдээ стандарт үйл ажиллагааг тогтоох боломжтой үүрэг бүхий шүүхийн ачаалал, хүний нөөцийг аргачлалын дагуу үе шаттайгаар тооцно.

ГБХШХШтХТ-д стандарт үйл ажиллагааг нь тооцох шаардлагатай шүүхийн дараах үүрэг байна. Үүнд:

Хүснэгт 3.Хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг

№	Холбогдох зохицуулалт	Зардал тооцох үүрэг
Шүүх		

ГБХШХШтХТ-ийн

1. 34.2.Шаардлагатай тохиолдолд эвлэрүүлэн зуучлалын шүүгч гэрлэгчдийг сэтгэлзүйчтэй уулзуулах арга хэмжээ авахыг эвлэрүүлэн зуучлалын хороонд даалгана. *Сэтгэлзүйч хүүхэдтэй холбоотойгоор гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тохиолдолд оролцоно.*

ГБХШХШтХТ-ийн

2. 16.1.Шүүхэд гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах чиг үүрэг бүхий шүүхийн ажилтан байна. *Гэр бүлийн нөхцөл байдлыг шаардлагатай тохиолдолд шүүгчийн захирамжийн дагуу шинжлэн судална.*

Аргачлалын 4.4.5.2-т зааснаар тохиолдлын тоог тогтоох боломжгүй үед хүний нөөцийн хэрэгцээг баримжаалан тооцно.

Эдгээрийн стандарт үйл ажиллагааг тодорхойлох, зарцуулах хугацааг нь гаргахдаа одоо хэрэгжиж байгаа адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авсан бөгөөд тэдний гүйцэтгэсэн ажил үйлчилгээгээр баримжаалж тогтоосон.

Иймд ГБХШХШтХТ-ийн 34.2-т зааснаар сэтгэлзүйч шаардлагатай тохиолдолд оролцох тул сэтгэлзүйчийн орон тоог баримжаалан тооцно.

Хуулийн төсөл дэх гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн орон тоо хуулийн төсөл батлагдсаар шаардлагатай болох бөгөөд ачааллаас хамааран шаардлагатай орон тоог баримжаалан тооцоолно.

ЭХХШтХТ-д стандарт үйл ажиллагааг нь тооцох шаардлагатай шүүхийн дараах үүрэг байна. Үүнд:

ЭХХШтХНӨтХТ-ийн 2 дугаар зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн,” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “холбогдох хэргийг” гэсний дараа “мөрдөн шалгах,” гэж, 14.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “үйлдсэн бол” гэсний дараа “энэ хуульд заасан өөр таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй тохиолдолд” гэж, 18.2 дугаар зүйлийн 1,2,3,4 дэх хэсгийн “Өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн, яллагдагч,” гэж, 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “сурган хүмүүжүүлэгчийг” гэсний өмнө “сэтгэлзүйч” гэж тус тус нэмсүгэй.” гэж заасантай холбогдуулан нутаг дэвсгэр бүрд 1 сэтгэлзүйч ажиллуулах шаардлагатай.

1.2. Нийт гарах хүний нөөцийн зардлын тооцоо, холбогдох нэмэлт зардал

Нийт гарах хүний нөөцийн зардлын урьдчилсан тооцоо хийхэд дараах төрлийн зардлын мэдээлэл цуглуулав. Үүнд:

- Цалин, бусад нэмэгдэл, тусламж
- Ажлын байрны, цахилгааны болон бусад материаллаг зардал
- Дагалдах бусад зардал

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч

Анхан шатны шүүх 2024 онд нийт 102385 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 12314 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, татан авах, нэгтгэх, харьяаллын дагуу шилжүүлэх, нэгтгэх, татан авах зэрэг ажиллагааг хийж, 73727 хэргийг хянан шийдвэрлэж, 16344 хэргийн үлдэгдэлтэй байна.

Гэр бүлийн эрх зүйн маргаан 2024 онд 6520 байсан байна.

Нийт 6520 гэр бүлийн эрх зүйн маргаан 2024 онд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлүүлснээс 3468 /53 хувь/ нь БЗД, СБД, ЧД, БГД, ХУД, СХД-т буюу бусад нутаг дэвсгэрийн харьяалах шүүхүүдэд 3052 гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэжээ.

Хүснэгт 4. Гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхүүдийн ачаалал

№	Шүүх	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Нийт
1	Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	72	725
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	92	1087
3	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	172	1163
4	Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	55	624
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	79	579

6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	38	266
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	291	2021
8	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	104	608
9	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	163	1326
10	Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	65	504
11	Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	39	540
12	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	357	2229
13	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	103	513
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	128	692
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	83	369
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	93	743
17	Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	121	1319
18	Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	69	670
19	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	80	725
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	226	1429
21	Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	96	732
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	60	356
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	35	279
24	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	41	259

25	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	47	348
26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	73	562
27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	26	257
28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	17	166
29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	29	301
30	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	905	9833
31	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	281	7195
32	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	268	7492
33	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	573	7725
34	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	627	7731
35	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	814	10221
36	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	80	972
37	Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	111	1092
38	Багахангай дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	7	74
39	Нийт дүн	6520	73727

Хуулийн төсөл дэх гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн орон тоо хуулийн төсөл батлагдсаар шаардлагатай болох бөгөөд ачааллаас хамааран дараах орон тоо шаардлагатай байна.

125 дотроо бол 1, 125-250 бол 2, 250-400 хооронд бол 3 гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч шаардлагатай гэж тооцоолов.

Хүснэгт 5. Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн шаардлагатай орон тоо

№	Шүүх	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Орон тоо
1	Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	72	1
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	92	1
3	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	172	2
4	Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	55	1
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	79	1
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	38	1
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	291	3
8	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	104	1
9	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	163	2
10	Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	65	1
11	Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	39	1
12	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	357	3
13	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	103	1
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	128	1
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	83	1

16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	93	1
17	Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	121	1
18	Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	69	1
19	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	80	1
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	226	2
21	Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	96	1
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	60	1
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	35	1
24	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	41	1
25	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	47	1
26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	73	1
27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	26	1
28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	17	1
29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	29	1
30	Нийслэл дэх гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх	3468	10
31	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	80	1
32	Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	111	1
33	Багахангай дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	7	1

	Нийт		49
--	-------------	--	-----------

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 206 дугаар тогтоолын хавсралтаар шүүхүүдийн тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан байх бөгөөд бүх давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхүүдэд тус бүр 1 сэтгэлзүйч байхаар заажээ.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 209 дүгээр тогтоолын хавсралтаар давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхийн тамгын газрын төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг баталсан. Төрийн үйлчилгээний ТҮ6 албан тушаалын зэрэглэлийн цалингийн хэмжээ 2,500,000 төгрөг байхаар заасан бөгөөд сэтгэлзүйч нь ТҮ6 албан тушаалын зэрэглэлд багтдаг.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэж заасны дагуу төрийн үйлчилгээний албан тушаалтанд сар бүр 10-25 хувийн ур чадварын нэмэгдэл олгодог.

Хүснэгт 6. Шаардлагатай орон тооны цалингийн зэрэглэл, хэмжээ

Албан зэрэглэл	тушаалын	Албан тушаалын зэрэглэл	Сарын цалингийн хэмжээ /мян төг/
ТҮ6		ТҮ6 Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч	2 500.000

Хүснэгт 7. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал, орон тоо тус бүрээр

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч		
Үндсэн цалингийн хэмжээ	Ур чадварын нэмэгдэл – 10%	Нийт цалин
2 500.000	250.000	2 750.000

Ийнхүү шаардлагатай орон тооны сарын цалинг дунджаар тооцсон бөгөөд нийт шаардлагатай хүний нөөцийн цалингийн дор тооцов. Үүнд:

Хүснэгт 8. Төрийн байгууллагын хүний нөөцийн нийт зардал

Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/	Цалингийн зардал /мян төг/	Хүний нөөцийн нийт зардал / сая төг/	Нийт зардал – 1 жилд /сая төг/
Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч 49	2 750.000	134.750.000	1.617.000.000

Түүнчлэн цалингаас гадна материаллаг зардлыг авч үзэх шаардлагатай бөгөөд шүүх нь шинээр бий болох орон тоог хангах материаллаг нөөцтэй гэж үзэн бичгийн ширээ, компьютер зэрэг тоног төхөөрөмж шинээр авахтай холбоотой зардал тооцоогүй бөгөөд харин эдгээртэй холбоотой элэгдэл, хорогдлын зардлыг тооцсон. Мөн материаллаг зардлын нарийвчилсан тооцоо гаргахдаа “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д жишээ болгон авсан ХЗДХЯ-ы нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав. Үүнд:

Хүснэгт 9. Нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ

Зардлын нэр	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Нийт	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал зардал	127,752
	Газрын төлбөр	22,253
	Нийт	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	160,000
	Тавилга, эд хогшил	100,000
	Барилга, байгууламж	65,670

	Нийт	325,670
Нийт		1,952,317

Дээрх тооцооноос үзэхэд нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1,952,317 төгрөг байна. Тус тооцоог ашиглан хуулийн төслийн улмаас төрийн байгууллага буюу төсөвт үүсэх нийт гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн хүний нөөцийн ачаалал, зардлыг тооцож гаргав. Үүнд:

Хүснэгт 10. Төрийн байгууллагуудын 1 жилийн хүний нөөцийн нийт зардал

Байгууллага – шаардлагатай орон тоо	Хүний нөөцийн зардал /цалин, саяг төг/	Материаллаг зардал /сая төг/	Нийт зардал /сая төг/
Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч 49	1.617.000.000	95.663.533	1.712.663.533

Ийнхүү шүүхэд гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн орон тоотой холбоотойгоор 1 жилд нийт 1.712.663.533 төгрөгийн хүний нөөцийн зардал нэмэгдэх тооцоо гарч байна.

Хялбарчлах боломж

Аргачлалын 4.7-д зааснаар хялбарчлах боломжийг шалгаж үр дүнг танилцуулах үе шатанд хуулийн төсөлд шинээр нэмж байгаа буюу өөрчилж байгаа зохицуулалттай холбогдон гарах төсвийн зардлыг багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар, боломж байгаа эсэхийг шалгана.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллээр, 2024 оны бүтэц, орон тоог батлахдаа орон тоог нэмэгдүүлж, 2025 оны улсын төсөвт 42 тамгын газарт шүүгч, шүүхийн туслахын орон тоо нэмэгдэж тусгагдсан байна. Иймээс энэ хүрээнд батлагдсан орон тоогоор сонгон шалгаруулж томилсон шүүгч, шүүгчийн туслахыг Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн тойргийн анхан шатны шүүх, Гэр бүл, хүүхдийн хэргийн Давж заалдах шатны шүүх, бусад нутаг дэвсгэрт иргэний хэргийн анхан шатны шүүхэд ажиллуулах байдлаар шүүгч, шүүхийн туслахын хүний нөөцийн зардал нэмж гаргах шаардлагагүй гэдгийг дурдах нь зүйтэй.

ГБХШХШТХТ-ийн 34.2-т зааснаар сэтгэлзүйч шаардлагатай тохиолдолд оролцуулах тул Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн тойргийн анхан шатны шүүхээс бусад нутаг дэвсгэрт тус бүр 1 сэтгэлзүйч шаардлагатай.

Шүүхийн ерөнхий зөвлөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн “Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйч, шинжээчийн дэмжлэг үзүүлэх тухай санамж бичиг”-т зааснаар Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн тойргийн анхан шатны шүүхэд 2 сэтгэлзүйч, 2 шинжээчийн дэмжлэг үзүүлэх, цалингийн зардлыг өөрийн байгууллагын төсөвт тусган ажиллахаар болсон.

Мөн аймаг, суманд тус бүр 1 сэтгэлзүйчийн орон тооны зардал шүүхийн төсөвт тусгагдаж, орон тоо батлагдсан байна.⁴

Иймд гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн 49 орон тооноос 2 орон тоог дээрх Шүүхийн ерөнхий зөвлөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн “Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйч, шинжээчийн дэмжлэг үзүүлэх тухай санамж бичиг”-ийн дагуу шийдвэрлэж, хялбарчлах боломжтой буюу 47 орон тооны 1.642.758.899 төгрөгийн зардлыг хялбарчлах боломжгүй байна.

Б.ЭХХШТХТ-тэй холбогдуулан төрийн байгууллагад үүсэх зардал

ЭХХШТХНӨТХТ-ийн 2 дугаар зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн,” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “холбогдох хэргийг” гэсний дараа “мөрдөн шалгах,” гэж, 14.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “үйлдсэн бол” гэсний дараа “энэ хуульд заасан өөр таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй тохиолдолд” гэж, 18.2 дугаар зүйлийн 1,2,3,4 дэх хэсгийн “Өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн, яллагдагч,” гэж, 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “сурган хүмүүжүүлэгчийг” гэсний өмнө “сэтгэлзүйч” гэж тус тус нэмсүгэй.” гэж заасантай холбогдуулан нутаг дэвсгэр бүрд 1 сэтгэлзүйч ажиллуулах шаардлагатай.

Цагдаагийн байгууллагад 120 албан хаагчийн орон тоо батлагдсан боловч 19 нь мөрдөгч, урьдчилан сэргийлэх, зөрчил шалгах 101 албан хаагч байна. Сэтгэлзүйч байдаг ч тэдгээр нь зөвхөн албан хаагчийн сэтгэлзүйн байдалд зөвөлгөө өгдөг байна.

Ял шийтгүүлсэн өсвөр насны хүн 2023 онд 222, 2024 онд 209 байх бөгөөд нийт дундаж ял шийтгүүлэгч 14000 гаруй байх тул үүний 1.5 хувийг ял шийтгүүлсэн өсвөр насны хүн эзэлж байна.⁵ Иймд шүүхээр ял шийтгүүлсэн өсвөр насны хүүхдийн тооноос үзэхэд, нийт эрүүгийн хэргийн хувьд өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэрэг бага байж болохоор байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 44.673 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9099 хэргээр буюу 25.6 хувиар өсөж, насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг 1373 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 103 хэргээр буюу 8.1 хувиар өсөж, бүх хэрэгт эзлэх хувийн жин 2.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр

⁴ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 206 дугаар тогтоолын хавсралт.

⁵ Монгол Улсын шүүхийн 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ https://www.judcouncil.mn/site/news_full/14795

буурсан байна. Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн 1191 буюу 86.7 хувийг хөнгөн, 181 буюу 13.3 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 70.7 хувь нь Улаанбаатар хотод, 29.3 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ.⁶

Иймд нутаг дэвсгэр бүрд хэргийн ачааллаас шалтгаалан 1, эсхүл 2 сэтгэлзүйчийн хүний нөөцийн зардал хэрэгцээтэй байна. Энэхүү зардлыг тохиоллын тоог тооцоолох боломжгүй тул баримжаалав.⁷

2023 онд нийт хүүхдийн үйлдсэн хэрэг 1270, үүнээс нийслэлд 791, 2024 онд 1373, үүнээс нийслэлд 971 байх бөгөөд ихэнх нь нийслэлд үйлдэгдэж байх тул Нийслэлийн гэр бүл, хүүхдийн тойргийн анхан шатны шүүхийн харьяалах дүүрэг болох БГД 1,2 хэлтэс /59 хэрэг/, БЗД 1,2,3 хэлтэс /226 хэрэг/, СБД 1,2 хэлтэс /164 хэрэг/, СХД 1,2,3 хэлтэс /146 хэрэг/, ХУД 1,2 хэлтэс /275 хэрэг/, ЧД 1,2 хэлтэс /72 хэрэг/ бүрд хэргийн ачааллаас шалтгаалж дараах тооны сэтгэлзүйч шаардлагатай.

Хүснэгт 13.Нийслэлийн Гэр бүл, хүүхдийн тойргийн анхан шатны шүүхийн нутаг дэвсгэр дэх цагдаагийн байгууллагад шаардлагатай сэтгэлзүйч

Нийслэл дэх Цагдаагийн хэлтэс	Хүүхдийн үйлдсэн хэргийн тоо	Шаардлагатай сэтгэлзүйч
БГД 1	34	1
БГД 2	25	
БЗД 1	84	2
БЗД 2	106	2
БЗД 3	36	1
СБД 1	115	2
СБД 2	149	3
СХД 1	55	1
СХД 2	41	1
СХД 3	50	1
ХУД 1	249	5
ХУД 2	26	1
ЧД 1	46	1
ЧД 2	26	
Нийт	20 сэтгэл зүйч	

Харин 21 аймгийн хувьд жилд хамгийн багадаа 6, дээд тал нь 62 хүүхдийн үйлдсэн хэрэг гарсан байна. Мөн Багануур дүүрэгт 14, Налайх дүүрэгт 12, Багахангайд 3 хүүхдийн үйлдсэн хэрэг 2024 онд гарсан байна.⁸ Иймд 21 аймаг болон 3 дүүрэг тус бүрд 1 сэтгэлзүйч байлгаж болно.

⁶ Цагдаагийн ерөнхий газрын стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны танилцуулга, 2025 он.

⁷ Цагдаагийн ерөнхий газрын стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны танилцуулга, 2025 он.

⁸ Цагдаагийн ерөнхий газрын стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны танилцуулга, 2025 он.

Сэтгэлзүйч нь цагдаагийн байгууллагад ажиллах тул төрийн тусгай албан хаагч байх, сарын цалин ТТ8 зэрэглэлээр бодвол 1,555,000 төгрөг байх⁹ бөгөөд нийт 44 сэтгэлзүйч сард 68,420,000 төгрөг, жилд 821,040,000 төгрөг үндсэн цалин төсөвт ачаалал үүсгэхээр байна. Үүнээс гадна цолны нэмэгдлийн хувьд, тухайлбал, дэслэгч—26% байдаг. Хэрэв дэслэгч цолны 26 хувийн нэмэгдэл /404,300 төгрөг/-ийг сэтгэлзүйчийн цалин дээр нэмбэл, нийт цалин 1,959,300 төгрөг байна. Иймд нийт цалингийн зардал 1,03 тэрбум төгрөг болохоор байна.

Материаллаг зардлын хувьд, хүснэгт 11-т заасны дагуу нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1,952,317 төгрөг байна. 44 сэтгэлзүйчээр бодвол жилд 85,901,948 төгрөгийн зардал үүсэхээр байна.

Нийт зардал нийт цалингийн зардал 1,03 тэрбум төгрөг болон 85,901,948 төгрөгийн нийт жилийн материаллаг зардал, нийт 1,115 тэрбум төгрөгийн зардал 44 сэтгэлзүйчийг мөрдөн шалгах үе шатанд хүүхдийн эрхийг хангах зорилгоор ажиллуулахад цагдаагийн байгууллагад үүсэхээр байна.

Хялбарчлах боломж

Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ гэж үзэн сэтгэлзүйчийг ажиллуулбал, цагаар бодон ажлын хөлсийг төлөх, ялангуяа ачаалал багатай нутаг дэвсгэрт буюу нийт 31 сэтгэлзүйчийг ачаалал бага хэлтэст ажиллуулах, үлдсэн ачаалалтай хэсэгт 13 сэтгэлзүйчийг төрийн тусгай албан хаагчаар ажиллуулах боломжтой.

Энэ тохиолдолд буюу байнгын орон тоог 13 болгоход улсын төсөвт, 329,698,303 төгрөгийн жилийн хүний нөөцийн зардал гарах бөгөөд гэрээгээр ажиллах тохиолдлын тоог тогтоох боломжгүй тул тодорхой хэмжээнд зардал гарна.

Гэвч гэрээгээр гүйцэтгүүлбэл, шаардлагагүй, ачаалалгүй хэсэгт үргүй зардал байнгын орон тооноос хамаарч гарахгүй, тухайлбал, цолны нэмэгдэл өгөх, эрт тэтгэвэрт гарах зэрэгт гарах улсын төсвийн зардалд хэмнэлт үзүүлж чадна.

Үнэлгээний үр дүн

ЭХХШТХНӨТХТ-ийн үзэл баримтлалаас үзэхэд, хүүхдийн үйлдсэн хэргийг шийдвэрлэх процесс ажиллагааг сайжруулахад чиглэсэн байх бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны үед хүүхдээс мэдүүлэг авахад сэтгэлзүйч заавал оролцох зохицуулалтыг бий болгохоор болжээ.

Үүнтэй холбоотойгоор, нутаг дэвсгэр дэх цагдаагийн байгууллагын ачаалал, хүүхэд гэмт хэрэг үйлдэх тохиолдол зэргийг харгалзан бодож үзэхэд, 44 сэтгэлзүйч

⁹ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ.

шаардлагатай буюу 1,115 тэрбум төгрөг шаардлагатай байна. Харин ачаалал бага нутаг дэвсгэрт төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэнд дээр бусдаар гүйцэтгүүлбэл, улсын төсөвт 785,301,697 төгрөгийн хэмнэлт үүсгэж, 329,698,303 төгрөгийн жилийн хүний нөөцийн зардал гарахаар байна.

Харин гэрээний үндсэн дээр цагаар бодож цалинжуулахад тохиолдлын тоог мэдэх боломжгүй тул жилд ямар зардал гарахыг мэдэх боломжгүй ч төрийн тусгай албан хаагчаар сэтгэлзүйчийг ажиллуулахгүй байснаар цолны нэмэгдэл, эрт тэтгэвэрт гарах зэрэг тусгай албан хаагчид зарцуулах улсын төсвийн ачаалал буурна.

ГБХШХШТХТ-өөр гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах зорилт тавьсан байна. Хэдийгээр энэхүү зардлын тооцоогоор Нийслэлд Гэр бүл, хүүхдийн тойргийн анхан шатны шүүх, бусад нутаг дэвсгэрт иргэний хэргийн анхан шатны шүүх гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэж, шинэ тутам нэхэмжлэл, хүсэлтийн төрөл нэмэгдэж байгаатай холбогдуулан 15 шүүгчийн орон тоо шаардлагатай гэж гарсан боловч энэхүү зардлыг ШЕЗ-өөс шүүхүүдийн тамгын газарт 42 шүүгчийн орон тоо нэмж, улсын төсөвт төсвийг нь батлуулсан байх тул зардлыг хэмнэх боломжтой гэж үзлээ.

Мөн адил гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэхэд сэтгэлзүйч оролцуулах үүрэг болгосон зохицуулалт хуулийн төсөлд байгаа хэдий ч шүүхээс төсвийг батлуулан орон тоог тавьсан байна.

Харин гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн 49 орон тооноос 2 орон тоог Шүүхийн ерөнхий зөвлөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн “Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйч, шинжээчийн дэмжлэг үзүүлэх тухай санамж бичиг”-ийн дагуу шийдвэрлэж, хялбарчлах боломжтой бөгөөд 47 орон тооны 1.642.758.899 төгрөгийн зардлыг хялбарчлах боломжгүй, улсын төсөвт үүсэхээр байна.

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн орон тоог дагаж мөрдөх журмын зохицуулалтын дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх тул 2026 оны төсөвт суулгуулах шаардлагатай.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

- Хууль тогтоомжийн тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ
- Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга
- Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- ХЗДХЯ-ы нэг ажилтны материаллаг зардал
- ШЕЗ-өөс ирүүлсэн мэдээлэл
- ЦЕГ-аас ирүүлсэн мэдээлэл
- Шүүхийн ерөнхий зөвлөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйч, шинжээчийн дэмжлэг үзүүлэх тухай санамж бичиг
- Монгол Улсын шүүхийн 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ https://www.judcouncil.mn/site/news_full/14795
- Цагдаагийн ерөнхий газрын стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны танилцуулга, 2025.

